

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244810

МОНГОЛ АМАН БОЛОН БИЧГИЙН УРАН ЗОХИОЛ ДАХЬ
ТЭНГЭРИЙН ЗҮҮДНИЙ ХҮНИЙ ДҮР, ӨГҮҮЛЭМЖИЙН
ХАРИЛЦАН ХОЛБОО

И.Даваадорж

Хураангуй: Аман болон бичгийн уран зохиол нь бие биедээ харилцан нөлөөлж байдаг. Ард олноо амаар тархсан үлгэр, туульсын дүр, өгүүлэмж нь бичгийн уран зохиолд нөлөөлөн хувирч байдаг бол нөгөөтээгүүр судар номноо тэмдэглэсэн үлгэр, домог ард олны дунд аман билиг болон тархах нь бий. Үүний тодорхой нэгэн жишээ нь тэнгэрийн зүүдний хүн, тэнгэрийн дагинатай холбоотой домог, үлгэр юм. Хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл зүйлсэд тэнгэрийн харьяат бүсгүйчүүд хүний орчлонд бууж, дунд тивийн хар тэргүүт хүнтэй ураглан хуримласан өгүүлэмж бий. Тэнгэрийн орноос бууж ирэн, хүмүүсийн дунд ахар богино хугацаанд оршиж байгаад, эргэн одож буй уг дүрийг тэнгэрийн дагина, тэнгэрийн зүүдний хүн хэмээн нэрийддэг. Бид эл өгүүлэлд Монголын уран зохиол дахь тэнгэрийн дагинын өгүүлэмж бүхий нэгэн домгийг структуралист аргаар шинжилж, тухайн домгийн дүр, өгүүлэмж болон зөрчил нь үлгэр, түүх домог болон орчин үеийн уран зохиолтой ямар харилцаа холбоотойг тодорхойлохыг зорилоо.

Аман болон бичгийн уран зохиолд тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмжийг ашиглахдаа ураг хурим, гэр бүлээс зайлсхийх зөрчлийг гол болгон өгүүлэгдэхүүн бүтээсэн нь уг үлгэр (архетип) бүхий бэлгэдэлт дүрийг үүсгэж байна.

Түлхүүр үг: *тэнгэрийн дагина, тэнгэрийн зүүдний хүн, ураг хурим, зөрчил, зууч, архетип*

Тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмж нь үлгэр, домогт түгээмэл тохиолдох нь бий. Тэнгэрийн зүүдний хүн (тэнгэрийн дагина) гэх ойлголтыг С.Дулам уран адилтгал – домог үг хэмээгээд, төв халхчуудын дунд “...ер бусын гоо үзэсгэлэнтэй, эелдэг сайхан зан аальтай атлаа нас богинотой хүнийг “тэнгэрийн зүүдний хүн” байгаад тэнгэртээ буцаад харьчихсан юм байлгүй хэмээн хэлэлцдэг” (2018а: 15) хэмээн тайлбарлажээ. Эндээс ажвал үлгэр, домгийн “тэнгэрийн дагина” болоод аман хүүрнэл, хууч яриа дахь “тэнгэрийн зүүдний хүн” гэх ойлголтод тодорхой холбоог ажиглаж болно.

Судлагдсан байдлын хувьд анхлан Ц.Дамдинсүрэн *Монголын судлал* (1970) сэтгүүлийн VIII дугаарт “Тэнгэрийн дагинын үлгэр” хэмээх өгүүлэл хэвлүүлжээ. Уг өгүүлэлд дэлхийн олон орны аман болон бичгийн уран зохиолд түгээмэл буй тэнгэрийн дагинын үлгэрийг судалсан нь “... домгийн тархцыг хэрхэн тогтоохын чухал жишээ болсон юм” (Дулам, 2009: 22). Уг өгүүлэлд тэнгэрийн дагина (тэнгэрийн зүүдний хүн)-ыг энгийн хар хүн, анчин цаламдан барьж аваад, гэрлэж бараалах тотем шүтлэгийн ул мөр бүхий өрнө, дорнын улс оронд түгээмэл

тархсан домгийг бүртгэн шинжилсэн. Эдгээрийн нэг хувилбар нь 2000 жилийн өмнө Энэтхэг орноо Бурхан багшийн цадиг болж, санскрит хэлээр *Судхана авадана* нэртэйгээр тэмдэглэгдсэн байна. Үүнээс улбаалан төвөд Ганжуур, Данжуурт орсон бөгөөд санскрит хэлээр нэг, төвөд хэлээр гурван эх олджээ. Дээрх эх бүгд монгол хэлнээ нэг бус удаа орчуулагдаж, судар номын шүтээний хэлбэрээс ард олноо аман байдлаар тархан, аман билиг болж хувирсан аж. Энэ тухай Ц.Дамдинсүрэн тэнгэрийн дагина (тэнгэрийн зүүдний хүн)-ы өгүүлэмж бүхий “Манибадра хааны тууж бол Ганжуур, Данжуурын шүтээний хүрээнээс гарч бичгийн уран зохиолын хэлбэрээр олон түмний дунд түгээмэл дэлгэрч, улмаар ардын аман зохиол болон хувирчээ” (Дамдинсүрэн ба бусад., 1976: 462-463) хэмээн дүгнэжээ.

Хүрэлшаа Гэсэрийг элдэв бартаа саад, хорт дайсныг дарахад туслагч баатар болох гурван үхүй (эгч) нь “...эртний шидэт үлгэрт гардаг тэнгэрийн гурван хун дагинын хувилбараас үндэслэлтэй” (1988) хэмээгээд үүнээс үүтгэл бүхий мотив “Мэргэн хөвгүүн Чаргин хоёрын тууль”, “Жангар”-ын туульд буй туслагч баатрын дүр, өгүүлэмжтэй нийцэж байна гэж үзжээ. Мөн “Монгол домгийн соёл судлал” бүтээлийн “Тотемизм хийгээд монголчуудын хун шувуун тотемын домог яриа” гэх бүлэгт долоон хувилбар домгийг задлан шинжилж, тотем шүтлэгтэй хэрхэн холбогдож буйг тодруулсан байна (2016: 158-194).

Д.Цэрэнсодном “Монгол ардын домог үлгэр” (2010 [1989]) эмхэтгэлийн “Овог аймгийн үүсэл гарал” бүлэгт тэнгэрийн дагина газарт бууж, жир хар хүнтэй ханилаад, буцан одож буй домгуудыг хэвлүүлжээ.

С.Дулам тэнгэрийн дагинын дүр, өгүүлэмжийг уламжлалт шашин шүтлэг, зан үйлтэй холбон үзэж, монгол аман зохиолд их зонхи өгүүлэх үд хүрдэггүй үен цагаан эм, хоногт хүрдэггүй хонин цагаан эмийг эзэмшин, дайны хөлд үрэгдсэн цэргийг сэхээх тэнгэрийн дагинын дүрийг “...угтаа ид шидийг эзэмдэгч удганы дүртэй холбоотой” (2020 I [2000]: 25-26) гэж дүгнэсэн байна. Тооны бэлгэдлийн хувьд дээд тэнгэр хийгээд дунд тив, төрөлтөнд улбарин хувьсаж, тусыг бүтээгч тэнгэрийн дагина, хун шувууны дүр нь гурвал бүтэц, гуравласан сүлжээний гадна оршдоггүй. Буриадын үүсэл гарлын тухай өгүүлэх “Хоридой мэргэний домог”, “Манихуар дагина” домог, “Хэзээний нэг хүү” үлгэр болон “Жангар” туульд гурван хун, гурван ангир, гурван шар толгойтой хун байдлаар дүрслэгдэж буй нь “...монгол домогт гардаг ертөнцийн гурвал бүтэц, дээд тэнгэрийн орон, дунд наргын орон, доод лусын орны ураг төрлийн гурвал холбооны үргэлжлэл нь “газарт буун” ирж байгаа хэрэг мөн” (2020 II [1999]: 56-57) хэмээн дүгнэсэн байна. Мөн “Академич Ц.Дамдинсүрэнгийн аман зохиол судлалын бүтээлүүд” өгүүлэлдээ тэнгэрийн дагинын өгүүлэмж бүхий “Хэзээний нэг хүү” үлгэрийг задлан шинжлээд, “... энэ үлгэрт гоо үзэсгэлэн хийгээд шунал тачаал гэсэн хүмүүний уг мөн чанар, уураг тархинд буй уг үлгэр (*archetype*)-ийг үзүүлсэн” (2018a: 15-16) хэмээн дүгнэжээ. С.Дулам “Алтай хэлт угсаатан үүссэн тухай домгийг харьцуулах нь” өгүүлэлд алтай хэлт угсаатан болох түрэг хэлт казах, киргиз, монгол хэлт хорь буриад, халх, урианхай нарын дунд шувуун дүрээр газар орноо бууж, ирсэн тэнгэрийн дагинаас өөрсдийгөө үүсэлтэй гэх домог

нийтлэг тархсаныг тэмдэглээд, “... энэ бол алтай язгуур хэлтний маш эртний, нийтлэг домог зүйн сан хөмрөгт хамаарах зүйлс хэмээн хэлж болно” (2018b: 414-415) хэмээн үзсэн байна. Эл домог нь сүлд шүтлэгийн нэгэн улбааг хадгалж байгаад, хожим шашин суртахууны нөлөөнд автан мартагдсан ажээ.

Х.Сампилдэндэв “Буриадын аман зохиол, зан үйлийг сурвалжилсан ажиглалт, тэмдэглэл”-дээ хорь буриадын уг гарвалийг Хун гүнжийн домогтой холбон авч үздэг хэмээгээд, “...шувууг онгон шүтээнээ болгосон дэлхийн бусад улс түмнүүдийн нэг адил Хорь буриадууд хун шувууг тотемоо болгосон нь өөрсдийгөө тэнгэрээс гаралтай гэсэн үзэл санаа юм” (2002: 58) хэмээн угсаатны бүлгийн шүтлэг мөргөл, үнэлэмжтэй холбон үзжээ.

Т.Баясгалан 2008 онд “Гонгорын хэлсэн үлгэр, туульс” бүтээлийг эмхэтгэн боловсруулж, хэвлүүлсэн. Эл эмхэтгэлд тэнгэрийн зүүдний хүний өгүүлэмж бүхий “Баруун хойд тивийг эзлэнхэн төрсөн Банчин Дайван хаан” үлгэр багтсан агаад эх материалын тайлбар, хавсралт хэсэгт ижил дүр, өгүүлэмж бүхий үлгэрийг жагсаажээ.

Б.Дайриймаа “Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж” бүтээлдээ буриад үлгэрийг онцгойлон дурдаад, “... буриад үлгэрт эхийн дүр болон цэцэн ухаант бүсгүйчүүд, мэргэн баатрын дүр голлох бөгөөд хун-бүсгүйн өгүүлэмж түгээмэл байна” (2017: 46) хэмээн үзсэн нь хун шувуун дүрээр дэлхий газраа буугч тэнгэрийн дагинын дүртэй холбогдох юм.

Тэнгэрийн зүүдний хүн, тэнгэрийн дагинын дүр, өгүүлэмж бүхий домог, үлгэрийг эмхэтгэн цуглуулж, задлан шинжлэн, тайлан тайлбарласан судлаачдын эдгээр бүтээлээс ажиглан үзвэл домог зүйн дүрийн эртний хэлбэр, шүтээний байдалтай холбогдохыг судлан үзэж, аман зохиолын бусад төрөлд зүйлд хэрхэн хувиран тархсаныг судалжээ. Бид эл өгүүлэлд тэнгэрийн зүүдний хүн, тэнгэрийн дагинын дүр, өгүүлэмжийг задлан шинжилж, орчин үеийн уран зохиолтой хэрхэн холбогдож буйг тайлан тайлбарлах юм.

Тэнгэрийн зүүдний хүний өгүүлэмж бүхий домгийг бүтэц-тэмдэг зүйн үүднээс шинжлэх нь: XX зууны философийн нөлөө бүхий дэг сургуулийн нэг структурализмын эхийг Швейцарын хэл шинжлэлийн шинжлэлч Фердинанд де Соссюр “Ерөнхий хэл шинжлэлийн курс” бүтээлээрээ тавьжээ. Уг онол хэл шинжлэлийн салбараас халин, антропологи, философи, утга зохиол, аман зохиол зэрэг эрдэм судлалын салбарт арга зүйн функц болж, түгэн дэлгэрсэн юм.

Структурализмын төлөөлөгч, антропологич Клод Леви-Стросс “...нийгмийн антропологиогийг төлөөллийн тогтолцооны байгууллыг судалдаг ухаан гэж үзсэн байна” (Бум-Очир ба бусад., 2018: 143). Тэр бээр төлөөлөл хэмээх ойлголтыг өмнө үеийн сэтгэгчдээс ялгаатай утгаар үзэж, бэлгэдэл хэмээн тодорхойлсон. Төлөөллийг хүн ухамсартайгаар задлан шинжилдэггүй, тухай төлөөлөл нийгмийн амьдралын гүн, хүний ухамсаргүй сэтгэлд нуугдан оршдог аж. Түүний үзсэнээр антропологи нийгмийн гүн дэх төлөөллийг шинжлэн үзэх бөгөөд тэрхүү төлөөллийг бүтэц хэмээн нэрлэжээ. Клод Леви-Стросс нийгмийн хамгийн чухал гурван бүтцийг судлан үзсэн нь “... ангиллын тогтолцоо, ураг төрлийн онол,

домгийн учир зүй гурав болно” (Бум-Очир ба бусад., 2018: 143). Эдгээр бүтцийг судалснаар алив соёлын байгууламж, тэдгээрийн гүнд буй бүтцийг тодруулах боломж бүрдэх билээ.

“Аман зохиолын бичвэрийг судлах дор хаяж ялгаатай хоёр структуралист арга байдаг” (Propp, 2009: xi). Нэг төрөл нь аман зохиолын текстийн бүтэц болон формал байгуулалд хандан, цуваа цаг хугацааны дагуу функцийг дараалуулан судалдаг синтагматик анализ юм. Энэхүү анализ нь В.Проппын 31 функцийн дагуу шидэт үлгэрийг шинжлэн үзэх “Үлгэрийн морфологи” бүтээлд төвлөдөг. Проппын синтагматик анализад аман зохиол судлаач тухайлсан текстийг нийгэм, соёлын хам сэдвээс (*context*) дангааршуулан авч үздэг тул дан бичвэр, өгүүлэгдэхүүний бүтэцтэй л харьцах ажлыг хийдэг (Propp, 2009: xii). Харин бичвэрийг бүтцийн үүднээс шинжлэн авч үзэх хоёр дахь хандлага болох парадигматик анализ нь тухайн текстийг зайлшгүй тодорхойлох хосмолжин эсрэгцлийг (*binary opposition*) олохыг зорьж байдаг. Энэ төрлийн шинжлэл нь “...элементүүдийг дэс дарааллаас салган, аналитик нэг болон түүнээс дээш бүдүүвчинд шинээр бүлэглэдэг” (Нямсүрэн, 2017: 19).

Парадигматик болон синтагматик анализын гол ялгаа нь хам сэдэвт анхаарч буй эсэхээс хамааран товойн гардаг (Propp, 2009: xii). Парадигматик анализ нь “...домог гэх мэтээс “олсон” парадигмаа өргөн хүрээнд ертөнцтэй, тодруулж хэлбэл сансар судлал, ертөнцийг үзэх үзэл гэх мэт соёлын бусад талтай холбохыг зоригтой оролддог” (Нямсүрэн, 2017: 19). Харин синтагматик анализ буюу “...цэвэр формал бүтцийн анализ нь бүхэлдээ өгүүлэмж хөөж, үг тоолдог” (Propp, 2009: xii). Бид энэхүү өгүүлэлд тэнгэрийн зүүдний хүний өгүүлэмж бүхий домгийг парадигматик анализын хүрээнд шинжлэн үзнэ. Ингэснээр тухайн домгийн гүн бүтэц, зөрчил юу болохыг илэрхийлж, түүнийг хэрхэн шийдсэн зэргээр дамжин нийгэм, түүхийн хам сэдэвтэй хэрхэн холбогдохыг авч үзэх өргөн бололцоо нээгдэх юм.

Клод Леви-Стросс бүхий л домог эсрэгцлийг ашигладаг бөгөөд эсрэгцлийг алсуур хуулбарлан үгүйсгэх явдал руу, эсвэл зуучлал руу тэмүүлдэг болохыг анхааралдаа авах нь зүй хэмээсэн байдаг. Эл арга зүйгээр домгийг авч үзвэл зөрчил дундын зуучтай, эсвэл зуучгүй хэрхэн саармагжиж буйг ажиглах боломжтой. Хосмолжин эсрэгцлийн голд байх зуучлагчийн жишээгээр дайн болон газар тариалангийн дунд дайны ургац хураалт болох хуйх, байгалиас соёл руу шилжихэд хувцас, хүн газар орноос зэрлэг шугуй руу шилжихэд хог хаягдал, үнс хөө нь гал голомт (газар), дээврийг (тэнгэр) нэгтгэж байдгийг дурджээ.

Клод Леви-Стросс домгийн дотоод бүтэц, зуучлагчийг тодруулах үүднээс түгээмэл шинжтэй доорх томъёог гаргасан (2013: 213).

$$f_x(a):f_y(b) \cong f_x(b):f_{a-1}(y)$$

Энд a , b гэсэн хоёр термин, x , y гэсэн функц өгөгджээ. Нэг терминийг эсрэгээр солих, мөн элемент бүрийн функц терминий утгыг урвуугаар нь эргүүлэх гэсэн хоёр тохиолдолд анхны болон термин, функц урвуугаар эргэсэн

удаах хоёр нөхцөл хоорондоо тэнцүүгийн харилцаа оршино (Стросс, 2013: 213; Нямсүрэн, 2017: 25-26).

Энэхүү томьёоллоор тэнгэрийн дагинын өгүүлэмж бүхий *Хун шувуу* домгийг шинжлэн үзье. Буриад угсаатны бүлгийн үүсэл гарлыг өгүүлэх домогт Барга баатрын гурван хүү Илюдар түргэн, Буриадай мэргэн, Хоридай мэргэний тухай өгүүлж, “...нутагт нь дайн дажин болж, ах дүү гурав тэндээс дүрвэн, Байгал далайн Ойхон (Ольхан) аралд нүүж очжээ” (МДЧ, 1999: 15) хэмээн баатрын нутаг орон, ах дүү гурвын аж байдлыг дэлгэр өгүүлдэг.

Байгал нуураас урагш нутаглах Хоридай мэргэн нэгэн налгар өдөр ан хийхээр явахад, “...огторгуйгаас гурван хун шувуу ганганалдан нисэж ирээд, далайн дэргэд бууж, өд сөдөн хувцсаа тайлж, охид болон хувираад, далайд шумбан сэлэн цэнгэцгээжээ дээ” (МДЧ, 1999: 15). Үүнийг ажсан Хоридай мэргэн ихээр догдлон гайхширч, нэгнийх нь хувцсыг аваад, бутны цаагуур нуугджээ. Гурван бүсгүй уснаас гарч, хоёр нь тэнгэр тийш одоход үлдсэн нэгийг нь Хоридай мэргэн аргагүйдүүлэн өөрийн гэргий болгодог. Ийн Хоридай мэргэн, дагина гэргийгээс таван хөвүүн, удаах гэргий Нагатайгаас найман хөвгүүн төрүүлэн, хоёр нь эндэж, буриад зоны 11 бүлэг үүсдэг. Домгийн төгсгөлд тэнгэрийн дагина, Хоридай мэргэн хоёул өтөлж, гэргийн үргэлж өмсөхийг мөрөөсдөг хувцсыг Хоридай мэргэн өгөхөд хун шувуу болон нисэж оддог.

Клод Леви-Строссын домгийн томьёогоор эл домгийг шинжлэн үзвэл доорх байдалтай байна.

$$f_x(a):f_y(b)\cong f_x(b):f_{a-l}(y)$$

x - хулгайлан, хууран барих

y – ураг төрөл болох, гэрлэх

a – Хоридай мэргэн

b - Хун шувуу дагина

Уг *a*, *b* терминийг *x*, *y* функцэд орлуулан үзвэл дараах үйлдлийн хэлхээг үүсгэж болно.

$f_x(a)$ – Хоридай мэргэн арга мэхээр Тэнгэрийн зүүдний хүн (Хун шувууг) хууран авч үлдэх

$f_y(b)$ – Хун шувуу Хоридай мэргэнд ижилдэн дасаж, Тэнгэрийн дагина хар хүнтэй ураглах

$f_x(b)$ – Хун шувууны хувилгаан “Залуугийнхаа хувцас чимэглэлийг гартаа барьж, нүдэндээ үзмээр санагдаад, заримдаа зүүдэнд үзэгдээд байх боллоо. Түүнийг минь үзүүлээч, өгөөч” (МДЧ: 1999, 16) хэмээн гуйж, хувцсаа аваад, Хоридай мэргэнийг хууран тэнгэрт одно.

$F_{a-l}(y)$ – Хоридай мэргэн гонь ганцаар үлдэж, ураглан хуримлах функцийг гүйцээшгүй болсныг илэрхийлнэ.

Дээрх томьёоноос харвал *a* термин болох Хоридай мэргэн нь нийгэм, түүхийн хам сэдэвтэй дүйцэх ураглан хуримлах, богтлон суух f_x функцийг идэвхжүүлэх

бөгөөд улмаар зуучлагч b өдөөн, дараах хэрэг явдлыг хөтөлдөг. Клод Леви-Строссийн үзсэнээр b зуучлагч домгийн үйл явдалд оролцсоны дараа “...эцсийн үр дүн нь зөвхөн эхний байр сууриндаа эргэж очихоос илүү ямар нэг томорсон байдалд хүрэх бичвэрийг л хамаарч...” (Соёлмаа, 2019: 97) байдаг. Ийн бодвол “Хун шувуу” домогт Хоридай мэргэн Тэнгэрийн дагиныг өөрийн гэргий болгоод алдсан хэдий ч, ураг удам өсөн нэмэгдэж, нэгэн угсаатан 11 бүл бүхий болсныг ажиж болно.

Клод Леви-Строссын энэхүү домгийн томъёог АНУ-ын аман зохиол судлаач Э.Кёнгас Маранда, Пьер.Маранда нар товч байдлаар томъёолсон байдаг (Соёлмаа, 2019: 97).

$$QS : QR :: FS : FR$$

QS	Анхдагч шийдвэр	Хоридай мэргэн Хун шувуу дагинын хувцсыг нуун, хууран авч үлдэх
QR	Анхны нөхцөл байдлыг илтгэх үр дүн	Хоридай мэргэн, Хун шувуу дагина нар ураглаж, үр хүүхэдтэй болох
FS	Сүүлчийн шийдвэр (Зуучлагчийн үйл ажиллагаатай холбоотой эргэлтийн цэг)	Хун шувуун ээж өөрийн залуу цагийг санагалзсан хэмээн өөрийн хувцсыг аван, хун шувуу болох
FR	Сүүлчийн үр дүн	Хоридай мэргэн өнөр олон хүүхэдтэй ч гэргийгүй үлдэх

Хүснэгт 1. Домгийн томъёоллын задаргаа

Эндээс харвал домгийн гол зөрчил тэнгэрийн үзэсгэлэн төгс Хун шувуун хувилгаан дагиныг өөрийн болгох гэсэн хүслээс үүдэж буйг харж болно. Домогт буй тэнгэр ба газар, ураг хурим ба хууран одох, газар үзэгдэх цаг зуурын гоо үзэсгэлэн ба түүнийг мөнхөд өөрийн байлгах хүсэл шуналын хосмолжин эсрэгцлийг уг домгийн томъёоллын b термин болох хун шувуу амжилттай зуучилж байна. Мөн тухайн зоны шүтэн дээдэлдэг амьтныг нэгэн цагт ирээд, одсон гэх холбогчоор дамжуулан үүсэл гарлаа мэтгэн тайлбарлах боломжийг олгожээ.


Хоридай мэргэн	Хун шувуун дагина
Газрын хүн	Тэнгэрийн дагина
Бузар	Ариун
Өөрийн байлгах эзэрхэг хүсэл	Харьяат бус байх эрмэлзэл
Ураг төрөл болох	Гэр бүлийн харилцаанаас зайлсхийх

Хүснэгт 2. Домгийн зөрчил

Домгийн зуучлагч ямар зөрчлийн дунд буйг дээрх хүснэгтээс тодорхой ажиж болох юм. Домгийн гол баатар (a термин) Хоридай мэргэн нь газрын хүн байж, тэнгэрийн дагиныг өөр болгон, ураг төрөл болохыг зорьдог. Харин хун шувуу хувьсгаатай дагина нь тэнгэрийн харьяат нэгэн байж, ураг төрлийн харилцааг үл хүсэмжилж буйг тодорхой илтгэнэ. Мөн тэнгэрийн дагина нь сайхныг

өөрийн байлгах хүний хүсэл ба ертөнцөд цаг зуур үзэгдээд өнгөрөх үзэсгэлэн гоо шинжийн дунд зуучлан хөтөлж, анхдагч зөрчлийг шийдсэн амжилттай зуучлагчийн байр сууринд байна.

Мөн үүний зэрэгцээ Э.Кёнгас Маранда, Пьер Маранда нар тухайн өгүүлэмж (мотиф)-ыг эх соёлын *хөмрөг* (corpus), тухайн соёлын хам сэдэвтэй уялдуулан судлах ёстой учир *соёл хооронд* (interculture) өгүүлэмж, мотифын хэлхээ үүсгэн судлах нь бэрхшээлтэй хэмээн үзжээ. Тийм учир структуралистууд тухайн эх соёлын хөмрөгийн хэсэг бүрийг шинжлэн үзэх ерөнхий ноттой арга, түүнээс улбаалан зааг ялгааг үүсгэдэг ерөнхий параметруудийг хөгжүүлсэн байна. Клод Леви-Стросс анчин болон түүвэрлэгч, баруун ба зүүн, дээр хийгээд доор гэх параметрийг онцолж байсан нь үүний жишээ юм (Köngäs & Pierre, 1971: 22-23). Судлаачид эл ерөнхий зарчимд суурилан параметрт бүдүүвч санал болгосон. Тэд өрнийн үлгэрт үндэслэн, “үлгэр зөвхөн нас, хүйс болон нийгмийн статусыг илэрхийлэх ойлголтыг өгдөг. Баатрын үйлдэл нь их зонхи баатраа тодорхойлно. Тиймээс европ үлгэрийн баатар нь доорх бүдүүвчид өгөгдсөн гурвалаар тодорхойлогдохуйц байдаг” (Köngäs & Pierre, 1971: 23) хэмээжээ (Бүдүүвч 1).



Бүдүүвч 1. Нас, хүйс болон нийгмийн статус тулгуурласан параметр бүдүүвч

Э.Кёнгас Маранда, Пьер Маранда нарын боловсруулсан параметрт бүдүүвчид тулгуурлан Хорь буриадын үүслийн домогт өгүүлэх баатруудын харилцаа, өгүүлэгдэхүүнд нөлөөлж буйг шинжлэн үзье. Тэнгэрийн зүүдний хүний өгүүлэмж бүхий эл домгийн зөрчлийг үүсгэгч Хоридай мэргэн нь “Бөртэ Чонын удмын дайчин цолтой Барга баатар ноён” (МДЧ, 1999: 14)-ы отгон хүү байдаг. Эндээс тухай баатар нь заяагдмал нийгмийн статустай буюу нийгмийн дээд бүлэгт харьяалагдах залуу эрэгтэй болох нь тодорхой илэрчээ. Нөгөө талаас хун шувуунаас улбарин хувьсаж, газар буусан тэнгэрийн дагина нь дээд тивд харьяалагдах, нэгэн биеэс нөгөө биед шилжих чадал бүхий нийгмийн дээд бүлэгт харьяалагдах залуу эмэгтэй юм. Угсаатны үүслийн домгийн эхэнд нийгмийн дээд бүлгийн залуу эр тэнгэрийн дагиныг богтлон гэрлэж буй бол домгийн төгсгөлд тэнгэрийн дагина хун шувуу хувцсаа өмсөн эргэн одож буй нь дээд бүлэгт

харьяалагдах залуу эмэгтэй гэх параметрт хамаарч буйтай холбоотой. Урвуулан үзвэл Хоридой улбарин хувьсах ид шидгүй, энгийн бүсгүйтэй хуримласан бол домгийн функцийн дэд үйлдэл буюу дутаан одох нь боломжгүй байх юм. Ийн харвал Клод Леви-Строссын домгийн томьёог тэнцүүлэх, зөрчлийг амжилттай шийдвэрлэх нь тухайн домгийн хоёр баатар нас, хүйс болон нийгмийн статусын хувьд ижил дүрслэгдсэнтэй уялдана.

Монгол үлгэр, түүх домог дахь тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмж: Улс үндэстний үүсэл гаралтай холбогдох домогт тэнгэрийн дагина, тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмжийг ураг хурим, гэр бүлтэй холбогдох зөрчлийг амжилттай давж буй зуучлагчийн үүргээр ашиглажээ. Тэнгэрийн гоо үзэсгэлэнт дагина, дээд тивд харьяалагдах нэгэн хүний орчлон буюу дунд тивд бууж буй өгүүлэмж дан ганц домгоор зогсохгүй монгол аман зохиолын бусад төрөл зүйл, тэр дундаа үлгэр, газар усны түүх домогт буй юм.

Монгол үлгэр дэх тэнгэрийн зүүдний хүний дүр өгүүлэмж. Тэнгэрийн дагинын дүр бүхий үлгэрийн үйл явдал дээд тэнгэрийн орон болон дунд хүмүүний ертөнцийн хооронд өрнөдгөөрөө онцлогтой. Энэхүү шинж нь домгийн баатар ертөнцийн зүй тогтолд баригдан, хун шувуун хувцсаа өмсөн одсон гэргийн араас үл хөдөлж чадах байдлаас чөлөөлж, тэнгэрийн орноо зорчих, дээд тивийн зан байдал, аяг шинжийг үзүүлж буйгаараа сонирхолтой.

Тэнгэрийн зүүдний хүн, тэнгэрийн дагинын тухай өгүүлэх “Баруун хойд тивийг эзлэнхэн төрсөн Банчин дайван хаан”, “Гөрөөчин”, “Дан цагаан морьтой Дандай өвгөн” зэрэг үлгэр нь алив зүйл дутагдсан гачаалаас эхэлдэг. Жишээ нь “Дан цагаан морьтой Дандай өвгөн үлгэр”-т “... Ганц хүүдээ үхэхээсээ өмнө авгай авч өгөөд, утааг нь үзээд, үхье гэж бодоод, боломжийн хүүхнийг эрээд явж” (ЗААЗ, 2004: 173) буйгаар эхэлдэг бол “Гөрөөчин” үлгэр “Хаан ерэн есөн жил хатнаасаа уйлах дуутай үр хүүхэд үзсэнгүй” (ТААЗ, 2002: 220) хэмээн үр хүүхэд үзэх хааны хүсэл үйл явдал өрнөх зангилаа болдог. Тэнгэрийн дагинын дүр бүхий үлгэрийн өгүүлэмжийн зангилаа нь гэрлэн ураглах, удам угсаа залгахтай холбоотой байдгаараа нийтлэг. Өгүүлэмжийн энэхүү шинж нь “...удам тасрахдаа тулахад тайж нар доод гэрээс бэр авч байсан. Бэр гэр угсаа залгах хүү төрүүлбэл “Тэнгэрийн бэр” болно” (Нандинбилиг ба Дулам, 2020: 239) гэх хууч ярианы зүйлтэй таацах агаад чухам яагаад тэнгэрийн дагина, тэнгэрийн зүүдний хүн хэмээн нэрийдсэнийг тайлах нэгэн сэжим болж байна.

Эдгээр үлгэрт алив зүйл дутагдаж гачигдсан баатарт хэрэгцээт зүйлийг өгөх, олох арга саамыг хэлэх баатар, шидэт туслагч нь мэлхий, бух зэрэгт хувирсан лус, баян эзэн хүн, лам зэрэг байдаг. Жишээ нь “Дандай өвгөн” үлгэрт өвгөн хоёр бух мөргөлдөж буйг алсаас хардаг. “Жаахан дөхөөд очтол нэг нь хүн болоод нуурын захад суугаад хоцорч гэнэ, нөгөө нь хүн болоод нуур луу гүйгээд орчихжээ”(ЗААЗ, 2004: 173). Нуурын хөвөөнөө үлдсэн хүн нь доод лусын эзэн хүн байх бөгөөд нуур руу зугтан орсон дээд тэнгэрийн дагиныг бугуйлдан авч, хүүтэйгээ гэрлүүл хэмээдэг. Уг өгүүлэмж Банчин Дайван хаан үлгэрт мөн давтагдах бөгөөд шар мэлхийд улбарисан Шар лусын хаанд хар мэлхийг барин өгч жинсрэгдүүлээд, шанд нь цаламтай болж, “...миний цалам биш, Шар лусын

хааны цалам” (ГХҮТ, 2008: 141) хэмээн хэлж тэнгэрийн гурван дагинын нэгийг барьж авах аргыг мэддэг. Эндээс ажвал нэгэн биеэс нөгөө биед дүрс хувиран, юүлэх чадалтай баатар, шидэт туслагчид гачаал дутагдалд өртсөн баатар туслан, тэнгэрийн дагиныг домог зүйн сэтгэлгээнээс үүдэл бүхий үг, үйлдэл хоёрыг хослуулан барьж авах арга ухааныг олж байна (Дулам, 2020 [1989]: 162).

Тэнгэрийн дагинын дүр, өгүүлэмж бүхий үлгэрт цаламдан барьж авсан дээд тивийн бүсгүйн гоо үзэсгэлэн, баатрын гадаад дүрслэл нь үлгэрийн өгүүлэгдэхүүнд нөлөөлөн, хөтөлдөг. “Дандай өвгөн” захчин үлгэрт “...суналзсан ногоон торгон дээлтэй хүүхэн гараад иржээ. Дан цагаан морьтой Дандай өвгөн харж чадалгүй алмайрч сүрдээд уначихжээ. Тэнгэрийн дагина илбийнхээ нударгаар ганцхан илээд босгочихжээ” (ЗААТ, 2004: 174) гэснээс ажвал харсан хүн гайхаш алдаж, унам гоо бүсгүй болох нь тодорхой. Мөн Банчин байван хааны долоон настай Дондой мэргэн хүү тэнгэрийн зүүдний хүнтэй ураглан хуримласнаас хойш хүн ард хов муу үг хэлэхээ байж, өвдөж зовохоо байсныг өгүүлдэг. “Энэ ертөнцийн амьтдыг өвчин хүрэх цагт нь буруу, зөв эм өгч, хатаахы нь хатааж, үхүүлэхий нь үхүүлж, алтан мөнгөн ембүү олж авдаг юм сан. Энэ авхайг ирсээр амьтан өвчин хүрэхээ байжээ” (ГХҮТ, 2008: 150) хэмээн хэлэх долоон шар эмч, хар санаат түшмэл, шивэгчин эмгэн нар гоо зүст тэнгэрийн дагиныг тэнгэрийн орноо буцаах аргыг сүвэгчилдэг. Харин “Дандай өвгөн” үлгэрт “...өвгөний хүү үзэсгэлэнт сайхан авгайгаараа гайхуулаад, ядуу хүмүүсийг дарлаж, мөлжөөд байхаар нь шоргоолжны дайн гэгчийг гаргаад, залууг дайнд хөөгөөд явуулжээ” (ЗААТ, 2004: 174).

Хаан, ураг удам залгах хатнаар дутаж байсан баатар үзэсгэлэнт гэргийтэй болж, бусад хатад хүмүүсийг ажрахгүй болсон нь зөрчил үүсгэж, цаашид хаан болон тэнгэрийн дагиныг холдуулан салгах, газар тэнгэрийн орноо үйл явдал шилжин өрнөх эх болдог. Жишээ нь “Манибадра хаан ба хар гөрөөчин” үлгэрт тэнгэрийн дагинатай урагласан хаанд өмнөх 108 хатан нь гурилаар зуурч хийсэн мэт санагдах болсон тул Манибадрын эцэг хаанд зүүд өгч, дайнд мордуулдаг. Манибадра хааныг хуурамч дайнд мордсон хойно тэнгэрийн дагиныг хорлохоор зэхэхэд дээд тивд зугтан гардаг (МАДҮ, 2010: 313-316). Уг өгүүлэмж “Банчин Дайван хаан” үлгэрт мөн давтагдах бөгөөд “...Шоргоолжин хааныхаас шороон түмэн цэрэг гараад, явж байгаа юм байна. Баруун хойд тивийг эзлэнхэн төрсөн Банчин Дайван хааныг... алаад, албат иргэн болоод, алтан тамга, аль нэг юмыг нь хурааж авна гэсэн бичиг байна” (ГХҮТ, 2008: 151) гэж хууран өгүүлдэг. Ийн Банчин Дайван хааны хүү Долоон настай Дондой Мэргэн хааныг худал дайнд мордуулсны хойно гэргий тэнгэрийн зүүдний хүнийг ширмэн байшинд шатаахаар завдахад, бүсгүй анх ирсэн шидэт хувцсаа өмсөн тэнгэрийн орноо оддог.

Уг хэсэгт тэнгэрийн зүүдний хүний өгүүлэмж бүхий домгоос эрс ялгагдах заагийг харж болно. Хоридай мэргэний домогт тэнгэрийн дагина, хун шувуу хувилгааны хувцас хэрэглэлийг барьцаалан авч, дунд тивд амьдрах хүсэлгүй баатрыг өөрийн гэргий болгодог. Харин шидэт үлгэрт газрын хүнтэй урагласан тэнгэрийн дагинад хатуу хэцүү үйл тохиолдоход, амиа арчлахын тулд дээд тив рүү нисэн одож буйг харж болно. Үүнийг лавшруулан тайлбарлавал

домоогт тэнгэрийн зүүдний хүн газрын хар тэргүүт хүнтэй ураглан хуримлах нь албадлагын шинжтэй үйл байсан бол шидэт үлгэрт дагина цаламлагдан баригдсан ч дунд тивийн хүнтэй амьдрах нь түүний өөрийн мэдэх хэрэг болжээ.

Үүний зэрэгцээ домогт гол зөрчил ураглан хуримласан баатар эр, тэнгэрийн дагинын хооронд өрнөж байсан бол шидэт үлгэрийн гол зөрчил ураглан хуримласан баатар эр, дагина болон тэднийг хүрээлсэн хам олонтой эсрэгцэж байна. Энэ нь Манибадра хаан, Долоон настай Дондой мэргэн, Дандай өвгөний хүүг хууран, өдүүлээгүй дайнд мордуулаад, тэнгэрийн дагинад хор хүргэж буйгаар нотолж болох юм.

Үйл явдал цааш өрнөж, баатар эр дайнаас эргэн ирэхэд хатан дагина нь тэнгэрийн орноо буцсан байдаг. Баатар эрийг тэнгэрийн орноо хүргэх зууч нь их зонхи хүлэг морь болдог бол Манибадра хаан, Хар гөрөөчин хоёр үлгэрт насны цөв болсон ламын орхимжоос барин нисэж тэнгэрийн орноо очдог.

Дээд тивд гарсан газрын баатар эрийн анхлан очих газар нь худаг юм. “Гөрөөчин” үлгэрт “... ганцаараа ургасан галбир зандан доор ирсэнд алтан мөнгөн хоёр худаг байв” (ТААЗ, 2002: 224) хэмээн дүрсэлдэг бол Банчин Дайван хаан үлгэрт “... харсан чинь алтан ховоотой, шүрэн хашаатай худаг дээр очоод зогсож байв” (ГХҮТ, 2008: 157) хэмээдэг. Анхлан очих газар худаг байх нь тэнгэрийн дагина газар очин буртаглагдсан гэх санааг эхлэн хэлж байна. Уг санааг “Банчин Дайван хаан” үлгэрт эгчийгээ ариулахаар худгаас ус авч буй тэнгэрийн дагина “Манай эгч доод оронд бууж, жаахан халчхаад (бохиртчихоод) ирсэн юм. Түүнийг угааж арчиж байгаа юм аа” (ГХҮТ, 2008: 158) гэснээр баталж болно. Уг хэсэгт үлгэрийн баатрын үг яриагаар дамжин тэнгэрийн орон ариун, газрын орон бузар гэх хосмолжин эсрэгцлийг илэрхийлжээ.

Үлгэрийн өгүүлэгдэхүүний туйл, төгсгөл хэсэгт тэнгэрийн хаан, газрын хүргэнээ шинжин сорьж, баатар эр тэнгэрийн дагинаа авч нутаг орноо эргэн ирж дуусдаг. Үүнээс ажвал газрын хар хүн, тэнгэрийн зүүдний хүнтэй ураглан хуримлах өгүүлэмжийн гол зангилаа нь удам угсаа залгах үйлд төвлөрчээ.

Газар усны түүх домог дахь тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмж. Газар орон, уулс усны байц шинж, үүслийг дүрслэн тайлбарлах газар усны түүх домогт тэнгэрээс улбарин буусан дагинын хувцас зүүсгэлийг хулгайлан авч үлдэх, тэнгэрийн дагина хүний орчлон болох дунд тивд өөрийн хүслээр бууж ирэх өгүүлэмж илэрч байна. Ховд аймгийн Булган сумын нутагт байх Гурван хүүхэд уулын түүх домогт нэгэн хавар тэнгэрийн гурван охин газрын нуурт бууж, усанд орж бүхүйд ан хийж явсан гурван эр сэм хараад, хувцас зүүсгэлийг нуун авсан тухай өгүүлдэг.

Гурван охин нуураас гарч хувцсаа эрээд эрээд олохгүй байтал анчин гурван эрчүүд инээлдэн шоолсоор хувцсыг барьсаар хүрч ирэхэд ичиж зовсон гурван охин анчин эрчүүдтэй юм ч ярьж чадсангүй, хувцсаа хүлээж хэсэг зогссоноо хоорондоо дохилцож, нэг дэх охин нь:

- *Ан гөрөө хороогчид минь цаашаа гэж хэлээд, хүрэн улаан уул болон хувирч тогтов гэнэ. Хоёр дахь охин нь:*

- *Хувцас хунар минь цаашаа гэж хэлээд, хүрэн ягаан уул болон тогтов гэнэ. Гурав дахь охин нь:*
- *Эд баялаг минь эзэндээ гэж хэлээд, уул болон хувирч тогтов гэнэ (МДЧ, 1999: 350).*

Тухайн газар орны хэлбэр бүтэц, эзэн савдаг зэргийг гурвын тоогоор багцлан илэрхийлсэн уг газар усны түүх домгийн гол зангилаа нь тэнгэрийн дагиныг шохоорхсон газрын хүн, дунд тивийн хүнээс айн ичсэн дээд тивийн дагинын хэрэг явдалд тулгуурладаг. Эл түүх домгийг үлгэр болон домгоос ялгарах онцлог нь “атан тэмээний ширээ бөх шиг” (МДЧ, 1999: 350) хэлбэр болон тухайн уулын эзнийг тодотгохын тулд тэнгэрийн зүүдний хүн газарт уул болж, хувиран үлдэж байна.

Мөн тэнгэрийн дагинын өгүүлэмжийг Өмнөговь аймгийн Говь Гурвансайхан уулын түүх домгоос харж болно. Эл домогт тэнгэрийн хааны бага охин лусын хааны мэдэлд байх хүний ертөнц рүү очихыг гуйдаг. Ийн тэнгэрийн хааны бага охин хоёр эгчдээ хэлж, лусын эзний харьяа нутаг болох хүний ертөнц рүү явдаг.

Гэтэл үүлэн дундаас харахад үзэсгэлэнтэй гэхэд хэлж барамгүй, урьд өмнө очиж байсан од эрхсүүдээс огт өөр нэгэн сайхан уулын оройг сонгон газардвал эргэн тойрны уулын оройгоор эвэртэн, туурайтан амьтад сэрийтэл зогсож хараад л элдэв төрлийн араатан амьтад өөд уруугүй гүйдээд, дээш харвал цэцэг түүний дээр алаг эрвээхэй босоож суун, хоорондоо хөөцөлдөнө (Мажаа (эмх.), 2022: 11).

Ийн тэнгэрийн хааны бага охин Гурвансайхан уулын сайханд татагдан, хүний оронд үлддэг. Тэнгэрийн хаан газрын оронд үлдсэн бага охиныхоо араас дунд охиноо, дунд охиныхоо араас ууган охиноо үүл хөлөглүүлэн одуулахад гурван охин цөм дунд тив, Говь Гурвансайхан уулын газар орны байц шинжид татагдан үлдэх аж. Бидний өмнө шинжилсэн домог, үлгэрт тэнгэрийн дагина, тэнгэрийн зүүдний хүнийг хувцас зүүсгэлийг хулгайлан авч үлдэж, цаламдан барих зэргээр авч үлдэж байсан бол уг домогт тэнгэрийн дагина нар өөрийн чөлөөт хүслээр дунд тивд үлдэж буйгаараа онцлог байна.

Тэнгэрийн дагина, тэнгэрийн зүүдний хүний дүр өгүүлэмж бүхий домог, үлгэр болон түүх домгийн зөрчил, дүр, сэдлийг хүснэгтлэн үзүүлбэл доорх байдалтай байна (Хүснэгт 3).

Төрөл зүйл	Зөрчил	Дүр	Анхдагч үйлдлийн сэдэл	Дэд үйлдлийн сэдэл	Утга
Домог	Тэнгэрийн гэргий Газрын нөхөр	Хүн ба хүн бус	Албадан гэрлэх	Зугтан дутаах	Гэр бүл болох
Үлгэр	Гэр бүл ба хам олон	Хүн ба хүн бус	Албадан гэрлэх	Аюулаас зайлах	Удам залгах
Түүх домог	Тэнгэрийн дагина Газрын хүн	Хүн ба хүн бус	Хүний орныг үзэх	Хүний оронд үлдэх	Газар орны байц, эзэн

Хүснэгт 3. Тэнгэрийн дагинын өгүүлэмж бүхий хүүрнэн өгүүлэх аман зохиолын гурван төрөл зүйл

Домгийн гол зөрчил нэг бүл болсон хосын хооронд, үлгэрт нэг гэр бүл ба тойрон байх хам олонтой зөрчилдөж байна. Энэ нь домогт тэнгэрийн дагина гэр бүлийн харилцаанаас зайлсхийж, Хоридай мэргэн хун шувууг хорин хувцас зүүсгэлийг хурааж буйгаар баатар эр болон тэнгэрийн дагинын зөрчил илэрнэ. Харин үлгэр, тэр дундаа шидэт үлгэрт тэнгэрийн зүүдний хүний зан төрх хам олонд үл таалагдаж, хорон санаа сэдэн, тэдгээрийн хорт үйлээс зайлахын тулд хувцас зүүсгэлээ өмсөн тэнгэрийн орноо очиж буйгаар газрын хүнтэй амьдрах нь дээд тивийн дагинын өөрийн хэрэг болохыг харуулдаг. Харин газар усны түүх домогт тэнгэрийн дагина газарт уул усанд улбарин хувирч үлдэх нь баатрын чөлөөт хүсэлд тулгуурлаж буй ялгааг харж болно.

Тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмж бүхий хүүрнэн өгүүлэх аман зохиолын гурван төрөл зүйлийн дүр, баатрын хувьд хүн болон хүмүүн бусын төрөлтний хооронд үйл явдал өрнөж буйгаараа ижил. Домгийн ерөнхий дүр нь хүн бус төрөлтөн, түүх домогт хүн, үлгэрт хүн болон хүн бус төрөлтөн хоёул байна гэсэн *Баскомын хүүрнэн өгүүлэх аман зохиолын гурван хэлбэрийн ангилал* (Three forms of prose narratives, according to Bascom) -тай зөрчилдөх агаад тэнгэрийн дагинын дүр, өгүүлэмж бүхий эдгээр төрөл зүйл нь домог зүйн шинжийг агуулж буйг илтгэх юм (Bascom, 1965: 5). Эл ангилал, таксомоос гадна хэл шинжээч, угсаатны зүйч Рут Финнеган түүх домог (*legend*) гэх нэр томъёонд шинэлэг байдлаар хандаж, болсон явдал, хууч яриа зэргийг тусгайлан тусгах болсон юм (Finnegan, 1992: 139).

Анхдагч үйлдлийн сэдлийг ажвал, түүх домгоос бусад төрөл зүйлд тэнгэрийн дагиныг албадан гэрлэх, богтлох ёсыг илэрхийлсэн нийгэм, түүхийн хам сэдэв илэрчээ. Харин түүх домогт эл сэдлийг заримдаг байдлаар илэрхийлсэн нь тухайн газар орны үзэмж байц нь тэнгэрийн хүнээс эрэл гаралтай, дээд тивийн төрөлтөн ч татагдан үлдсэн гэх далд утгыг илэрхийлнэ.

Гэрлэн бараалах, хүмүүний дунд тивд үлдэх зэрэг анхдагч сэдлийг дагалдан илрэх дэд хэрэг явдлын сэдэл нь домогт гэр бүлийн харилцаанаас зайлсхийх байдлаар, үлгэрт гэр бүлийн харилцааг хам олон эсэргүүцэх буйгаар илэрчээ. Эндээс домгийн үндсэн зөрчлийг үлгэрч хувирган ашигласныг нотолж болно. Эл дэд үйлдлээс улбаалан утгыг тодруулбал домог болон үлгэрт гэр бүл болж, ураг удам залгахыг чухалчлан үзсэн нь тодорхой агаад харин түүх домогт газар усны байц шинж, орны эзнийг тодотгохын тулд тэнгэрийн дагинын дүр, өгүүлэмжийг ашиглажээ.

Монголын орчин үеийн уран зохиол дахь тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмж: Монголын орчин үеийн хүүрнэл зохиолын дотор тэнгэрийн дагинын өгүүлэмж бүхий өгүүллэг, тууж нэг биш. Зохиолч Ч.Галсангийн “Тэнгэрийн охин” өгүүллэг, Д.Оюунчимэгийн “Тэнгэрийн цаг болоогүй” туужид олны дунд цаг зуур үзэгдээд өнгөрөх үзэсгэлэн гоо охид, бүсгүйчүүдийн тухай өгүүлдэг. Орчин үеийн уран зохиолын эдгээр жишээ аман зохиолын төрөл болох домог, үлгэрт буй тэнгэрийн дагинын дүр, өгүүлэмжтэй хэрхэн нийцэхийг авч үзье.

Тэнгэрийн зүүдний хүн газарт буух. Бидний задлан шинжилсэн “Хун шувуу” домогт гурван хун шувуу гунганалдан нисэж ирээд, өд сөдөн хувцсаа

тайлж, охид болон хувирахыг Хоридай мэргэн үздэг. Харин Ч.Галсангийн “Тэнгэрийн охин” өгүүллэг “Тэр охин сүүн тасгийн олон айлын дунд нэг л өдөр торойтол зогсож байжээ. Чухам хэн түрүүлж харсныг, тэгээд яасныг мэдэхгүй... туулай шиг бүлтгэнэн байж билээ” (Галсан, 2017: 218) хэмээн эхэлдэг. Мөн Д.Оюунчимэгийн “Тэнгэрийн цаг болоогүй” туужид “...хөглөрөх хэдэн навтгар байшинтай эл бяцхан сууринд нэг л өдөр Од бууж ирлээ. Гэхдээ бүр гэгээн цагаан өдрөөр шүү!” (Дашням ба Батбаяр (эмх.), 2015: 217) хэмээн зохиолч өөрийн дуу хоолойгоор эгэл жир төрөлтөн биш нэгэн тэрхүү сууринд ирж буйг өгүүлдэг. Ийн харвал эртний домогт тэнгэрийн дагина улбарин, хувьсах шидээр хүнээс жигүүртэнд хувилж байсан бол орчин үеийн уран зохиолын жишээнд ертөнцийн хуульд хүрээлэгдэн, хаанаас ч юм гэнэт ирсэн нэгэн бүсгүй гэх мэтээр өгүүлсэн байна. Эндээс аман болон бичгийн уран зохиолын тодорхой ялгаа заагийг ажиг болох агаад тэрхүү гол дүрийн үүсэл гарлыг далдалж, шидэт нууцлагдмал шинжийг товойлгожээ.

Тэнгэрийн зүүдний хүний гадаад гоо. Тэнгэрийн дагина тухайн газар очоод, хүн зоны сэтгэлийг татаж, ааш занг эелдэг эерүү болгох өгүүлэмж нь элбэг. Д.Оюунчимэгийн “Тэнгэрийн цаг болоогүй” туужид дүрийн гоо сайхныг гаднаас тоочилгүй, Од хэмээх бүсгүйг тойрох дүр, баатруудад хэрхэн нөлөөлж, ямар өөрчлөлт гарч байгаар тодотгожээ. Жишээ нь Од хэмээх бүсгүйг гэнэт ирснээс хойш хүн эмнэлгийн дарга Шаргай эмч “...бусад үед бол тачигнатал загнаад, өрөөнөөсөө хөөж гаргах хэрэггүй олон хүмүүсийг эмч анзаарсангүй юу, эсвэл уурлах мэдрэмж нь алга болчихсон ч юм уу, малыйтал инээмсэглэж... Одоор ганц нэг үг хэлүүлэн нэмэр хачир авах гэж чармайж байв” (Дашням ба Батбаяр (эмх.), 2015: 219-220) гэх зэргээр тухайн дүр, баатарт гарсан өөрчлөлтөөр дамжуулан илэрхийлжээ. Ч.Галсангийн “Тэнгэрийн охин” өгүүллэгт Хасаа хэмээх дүрийг “...нүүр царай, гар хөл нь биднийх шиг шалбарч шархалж, холцруутаж саарьтаагүй, зунжингаа түүхий сүүний зөөхий дотор байлгаж байгаад, сая гаргаж ирсэн юм шиг булбарай, тунгалаг хийгээд товгор духтай...” (Галсан, 2017: 218) гэх мэтээр гадаад царай, төрхийг тоочин дүрсэлжээ. Мөн “...Хасааг гэртээ байлгаж, биедээ дасгах, бүр өргөж авах гэсэн хүн нэг бус. Манай аав, ээж хүртэл ганц охиндоо ижил хийх юм болж...” (Галсан, 2017: 218) гэх мэтээр зохиолын дүрийг бусад дүр баатрын үйлдлээр дамжуулан тодотгосон байна. Дээр өгүүлсэн хоёр жишээг харвал тухайн зохиолын дүрүүд нь жир хүнээс анги өөр, харь элгийн бусад хүнийг өөртөө татах гоо төгс байдлаараа, мөн хаанаас ч юм гэнэт ирсэн тэрхүү шинжээрээ тэнгэрийн зүүдний хүний шинжийг илэрхийлжээ.

Гэр бүлийн харилцаанаас зайлсхийх. “Хун шувуу” домгийн гол зөрчил нь тэнгэрийн дагиныг өөрийн болгон суух ертөнцийн хар тэргүүт хүний хүсэл, ураг төрлийн харилцаанаас зайлсхийх тэнгэрийн зүүдний хүний эрмэлзэл юм. Орчин үеийн уран зохиолын эдгээр жишээнд ч ураглах, гэр бүл болох, эл харилцаанаас зайлсхийх сэдвийг дэлгэр өгүүлсэн байна.

Ч.Галсангийн “Тэнгэрийн охин” өгүүллэгт Хасаа гэх охиныг олон айл өргөж авах гэсэн боловч эс бүтсэн тухай өгүүлдэг. Мөн зохиолд “...айлаас айл дамжин явсаар сүүл тийшээгээ үр хүүхэдгүй нэгэн айлд тогтох аястай...” (Галсан,

2017: 218) болдог. Гэвч Хасаа охин сургуульд орох болоход өргөсөн эцгээрээ овоглохоос дургүйцэн татгалзсанд Тэнгэрийн Хасаа хэмээн тэмдэглэдэг. Эндээс ажин харвал уг охинд Хун шувуу дагинатай ижил харьяат бус байх эрмэлзэл цусан төрөл бус хүнээр овоглон, нэгэн бүлд багтах аас татгалзах байдлаар илэрч буй юм. Ийн харвал домгийн суурь шинжит өвөр төрх, зөрчил орчин үеийн уран зохиолд илэрч, дүрийн хэв шинжийг болгож байна.

Зохиолч Д.Оюунчимэгийн “Тэнгэрийн цаг болоогүй” туужид тэнгэрийн зүүдний хүнийг буйд сууриныхан бэр болгон авч, ураг төрөл барилдах эрмэлзлээс үүдэн, зохиолын туйлд хүрдэг. Сумын наадмын болох “...чухам тэр үеэс л нэгэн шинэ ярианы сэдэв хөндөгдсөн нь Одтой ураглах тэр азтай залуугийн тухай байжээ” (Дашням ба Батбаяр (эмх.), 2015: 225). Бүр сумын дарга “... түрүү бөхөд бай шагнал гардуулахдаа “За тэгээд нутагтаа бүл нэмж, дараа жил гэхэд биднийгээ хуримдаа уриарай. Ийм сайхан залуустай байхад нутаг маань бэрийн сайхан ирэх байлгүй” (Дашням ба Батбаяр (эмх.), 2015: 225) хэмээн илт тодорхой хэлдэг. Энэ үеэс эхлэн зохиолд өмнө зөвхөн зохиолчийн дуу хоолойгоор дүрслэгддэг объектив шинжтэй дүр идэвхтэй үйлдэл хийж эхлэн, Од гэх дүрийн бие даасан шинж товойн ялгардаг. Сумын хүн эмнэлгийн даргын хүү мөн шүлэгч нэгнийг үл тоон, сургуулиас “...дөрөвдүгээр ангиас гарсан, баруун нүдний хараа муу гээд цэргийн албанд ч яваагүй, уулын Дулам гэгч ганц бие авгайн эр ганц хүү бөгөөд хөдөө нутгийн хаана ч тааралдах, ердийнхөөс ердийн...” (Дашням ба Батбаяр (эмх.), 2015: 229) Борзоон гэх залуутай болж эхлэх нь тэр. Гэвч тэр хоёр нэг айл бололгүй Борзоон залуу “Уртын сайхан хүрэн” гэх дууг дуулсаар салснаас хойш Од алга болох нь тэр. Эндээс харвал, бүсгүй өөрийн хүслээр нэгэн эрийг сонгосон ч ураглан хуримлаж эс чадсан, домгийн зөрчлийн тонгоруу хувилбар юм.

Дээрх тууж, өгүүллэгт нэгээхэн цаг үзэгдээд өнгөрдөг, үзэмж гоо төгс тэнгэрийн дагинын тухай өгүүлсэн нь төгсгөлийн хэсгээс тодорхой харагдана. “Тэнгэрийн охин” өгүүллэгийн төгсгөлд би баатар л ганцаар нэгэн цагт ирсэн Хасаа охиныг санан дурсаж, нутгийн түмэн мартсан байдаг бол “Тэнгэрийн цаг болоогүй” туужид зохиолч өөрийн үгээр “...Тэнгэрийн охин, Газрын хүү хоёрын хайр дурлалын түүхийг харз тэдэнд нар сарны хэлээр өгүүлэх л байсан байх даа...” хэмээснийг зохиолч бичиглэв хэмээн төгсдөг.

Домог зүйн шинжийг хадгалсан эл бэлгэдэлт дүрийг аналитик психоанализын төлөөлөгч К.Г.Юнгийн онолтой холбон тайлбарлаж болно. К.Г.Юнг хүний сэтгэцийг эго, хувийн ухамсаргүй, хамтын ухамсаргүй гэсэн гурван хэсгээс бүрддэг хэмээн үзсэн. Тэр бээр хүний сэтгэцийн бүтцийг хиндү шашны ойлголттой хоймсуулан тайлбарлаж, бидний эго болон ухамсар нь өөр өөр, анги тусдаа боловч уг сууриараа холбоотой хэмээжээ. “Хиндү шашинд хувь хүний Эго-г далай тэнгисийн аралтай адилтгасан” (Цэрэнханд, 2018: 55) ба түүний дор хувийн ухамсаргүй сэтгэл, тэдгээрийг холбогч хамтын ухамсаргүй сэтгэл оршдог хэмээн үздэг. Хувийн ухамсаргүй сэтгэл нь бие хүнийг нэгэн цул болгож байдаг хувийн элементээс бүрддэг бол хамтын ухамсаргүй сэтгэл нь “хүн төрөлхтний нэгдмэл шинж чанарыг агуулсан” (Цэрэнханд, 2018: 55) байдаг.

Хамтын ухамсаргүйд багтах архетип нь бидний өвөг үеийн анхдагч туршлагаас бий болсон дурсамжууд бөгөөд хэлбэр, агуулгын хувьд шидэт домгийн сэдлийг багтаадаг. Иймээс бид архетипийг рационал байдлаар танин барьдаг биш, харин интуицээр мэдрэн таньж болох ухамсаргүй уламжлагдсан ирсэн бэлгэдэлт дүр юм. Архетипээр дамжуулан, улс үндэстэн бүхэнд байх нийтлэг өгүүлэмж бүхий үлгэрийг тайлан, мөн зүүдэнд үзэгдэх тухайн хүний дурсамж, туршлагатай холбоогүй өгүүлэмжийг анхдагч өвгийн шүтлэг бишрэлийн ул мөр, тэмдэг бэлгэдлээр дамжуулан тайлан тайлбарлах боломжтой.

Ч.Галсангийн “Тэнгэрийн охин”, Д.Оюунчимэгийн “Тэнгэрийн цаг болоогүй” зохиолд ураг төрлийг тойрсон зөрчлөөс өөрийг чөлөөлөн авч үлддэг эмэгтэйн дүр нь мөнхийн гоо төгс тэнгэрийн дагиныг цаламдан авч ураглан хуримлах овог аймгийн үүслийн домогтой ижил шинжтэй. Хэдий хоёр өөр зохиолч бичсэн хэдий ч их зонхи нэгэн шинжийг илтгэх дүрийг бүтээсэн нь мөн хамтын ухамсаргүй давхаргад нэвчин байрласан тэнгэрийн зүүдний хүний ул мөр, хэв дардсыг харуулж байна.

Дүгнэлт

Монгол аман болон бичгийн уран зохиолд тархсан тэнгэрийн зүүдний хүн, тэнгэрийн дагины өгүүлэмжийг XX зууны нөлөө бүхий онол болох структурализмын хүрээнд авч үзлээ.

Аман зохиолын бичвэрийг задлан шинжлэхэд ашиглах структуралист анализын хоёр төрлөөс парадигматик анализыг сонгон хорь буриадын үүсэл “Хун шувуу” домгийг шинжлэн, домгийн дотоодод байх хосмолжин эсрэгцэл, тухайн зөрчлөөс хэрхэн зуучлагчийн тусламжтай дэвшилд хүрч буйг тодорхойлов. Ийн үзэхэд эл домог нь тэнгэр ба газар, мөнхийн үзэсгэлэн гоо болон хар хүний шунал хүсэл, ураглан хуримлах ба гэр бүлээс зайлсхийх хосмолжин эсрэгцлийг дотооддоо агуулж, тэнгэрийн дагина болох хун шувуу нь домгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэж, зөрчлийг тодорхой хэмжээнд өргөтгөн дэвшилд хүргэжээ. Үүнийг буриад угсаатны бүлгийн 11 бүл үүссэнээр тайлбарлаж болох бөгөөд домог нь тухайн угсаатны бүлэг өөрийн үүсэл гарлыг тэнгэрийн гоо жигүүртэнтэй холбон үзэх эрмэлзлийг илэрхийлж байна. Мөн түүнчлэн тэнгэрийн дагина Хоридай мэргэнийг орхин одож буй нь Э.Кёнгас Маранда, Пьер Маранда нарын нас, хүйс болон нийгмийн статуст тулгуурласан параметрт бүдүүвчийн нэгэн хэмжээст зэрэгцэн оршиж буйтай холбоотой.

Ураг хуримыг дагасан домгийн зөрчлийн хэлбэр үлгэрт уламжлагдахдаа гэр бүл, тухайн хам олонтой зөрчилдөх болон хувирчээ. Хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл зүйлд нийтлэг илэрч буй албадан гэрлэх өгүүлэмжийн удаагаар домогт тэнгэрийн дагина, тэнгэрийн зүүдний хүн хар толгойт нөхрөөс зугтан дутааж буй бол үлгэр болон түүх домогт тэнгэрийн дагина хүний дунд тивд өөрийн чөлөөт хүслээр үлдэж буйгаараа ялгаатай юм.

Тэнгэрийн зүүдний хүний дүр, өгүүлэмж бүхий хүүрнэн өгүүлэх аман зохиолын гурван төрөл зүйлийн үйл явдлыг хүн болон хүн бусын төрөлт дүр, баатар хөтөлж буй нь ижил байна. Эл шинж нь Баскомын хүүрнэн өгүүлэх аман зохиолын гурван хэлбэрийн ангилалтай зөрчилдөж, судлан буй дүр, өгүүлэмж бүхий гурван төрөл зүйл домог зүйн шинжийг агуулж буйтай холбоотой байна.

Домог, үлгэрт үйлдлийн анхны сэдлийг албадан гэрлэх, богтлох ёсыг илэрхийлсэн нийгэм, түүхийн хам сэдэвт таацах шинжийг илтгэж буй бол түүх домогт уг сэдлийг заримдаг байдлаар илэрхийлсэн нь газар орны үзэмж байцыг товойлгон илтгэх, орны эзнийг дүрслэх төрөл зүйлийн онцлогтой холбоотой.

Орчин үеийн уран зохиолын жишээ болох Ч.Галсангийн “Тэнгэрийн охин” өгүүллэг, Д.Оюунчимэгийн “Тэнгэрийн цаг болоогүй” тууж нь тэнгэрийн дагинын түгээмэл өгүүлэмжийг хадгалжээ. Гоо сайхан зүстэй ч нас богино тэнгэрийн зүүдний хүн гэнэт гарч ирээд, мартагдан алга болох, энэ хооронд хүрээлэн бүхүй хүмүүсийн сэтгэл зүрхийг татах боловч ураг хуримын үйлээс зайлсхийж буй нь эх домгийн өгүүлэмжтэй нийцнэ. Эдгээр өгүүллэг туужид тэнгэрийн дагина ирсэн орон руугаа буцах өгүүлэмжийг буйд тосгоны хэн бүгд мартсан байх, зохиолч өөрийн дуу хоолойгоор зарлах зэргээр илэрхийлсэн нь хоромхон зуур үзэгдээд өнгөрдөг тэнгэрийн зүүдний шинжийг гурамсан нотолно. Энэхүү аман болон бичгийн уран зохиолд уламжилсан тэнгэрийн дагинын дүрийг сэтгэл судлаач К.Г.Юнгийн онолтой холбон тайлбарлах боломжийг олгож байна. Хамтын ухамсаргүй сэтгэлийн бүрэлдэхүүн болж, үеэс үед уламжлагдан ирсэн энэхүү дүр нь анхдагч өвөг үеийн итгэл бишрэлийн ул мөр болох архетип мөн гэдгийг дээрх жишээнээс тодорхой харж болох юм.

Ном зүй

Эх хэрэглэгдэхүүн

- Баясгалан, Т. (эмх.). (2008). *Гонгорын хэлсэн үлгэр, туульс*. Улаанбаатар: Бемби сан.
- Галсан, Ч. (2017). *Туужууд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Катуу, Б. (эмх.). (2002). *Торгууд ардын аман зохиол*. Улаанбаатар: ВСІ.
- Катуу, Б ба Пүрэвжав, Э. (эмх.). (2004). *Захчин ардын аман зохиол*. Улаанбаатар: Бемби сан.
- Мажаа, Л. (эмх.). (2022). *Говийн Гурвансайхан нутаг орны домог оривой*. Улаанбаатар: New Indigo.
- Оюунчимэг, Д. (2015). Тэнгэрийн цаг болоогүй. In Л.Дашням ба Д.Батбаяр. (Эмх.). *Монголын өгүүллэг, туужийн дээж*. (217-255). Улаанбаатар: Монсудар.
- Цэрэнсодном, Д. (эмх.). (2010 [1989]). *Монгол ардын домог үлгэр*. Улаанбаатар: Тод бичиг.
- Сампилдэндэв, Х. (эмх.). (1999). *Монгол домгийн чуулган*. Улаанбаатар: Интерпресс.

Судалгааны бүтээл

- Бум-Очир, Д ба Мөнх-Эрдэнэ, Г. (2018). *Нийгэм-соёлын хүн судлалын онолын үүд*. Улаанбаатар: МУИС Пресс.
- Дайриймаа, Б. (2013). *Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж*. Улаанбаатар: Соёмбо принтинг
- Дамдинсүрэн, Ц. (1970). Тэнгэрийн дагинын үлгэр. *Монголын судлал VIII*, 47-107.
- Дамдинсүрэн, Ц ба Цэнд, Д. (ред.). (1976). *Монголын уран зохиолын тойм II*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл.
- Дулам, С. (2009, 2020). *Монгол домог зүйн дүр* (Хоёр болон гурав дахь хэвлэл). Улаанбаатар: Битпресс (Анхны хэвлэл 1989).

- Дулам, С. (2020 II). *Монгол бэлгэдэл зүй I: Тооны бэлгэдэл зүй* (Гурав дахь хэвлэл). Улаанбаатар: Битпресс (Анхны хэвлэл 1999).
- Дулам, С. (2020 I). *Монгол бэлгэдэл зүй II: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй* (Гурав дахь хэвлэл). Улаанбаатар: Битпресс (Анхны хэвлэл 2000).
- Дулам, С ба Нандинбилиг, Г. (2016). *Монгол аман зохиолын онол I: Аман яруу найраг*. Улаанбаатар: МУИС Пресс (Анхны хэвлэл 2007).
- Дулам, С. (2018a). Академич Ц.Дамдинсүрэнгийн аман зохиол судлалын бүтээлүүд. *МУИС Профессорын эрдмийн өв - Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа*, 12-17 (Анхны хэвлэл 2008).
- Дулам, С. (2018b). Алтай хэлт угсаатан үүссэн тухай домгийг харьцуулах нь. *МУИС Профессорын эрдмийн өв- Монгол аман зохиол, харьцуулсан аман зохиолын судалгаа*, 409-415 (Анхны хэвлэл 2013).
- Клод Лэви-Стросс. (2013). *Бүтцийн антропологи*. орч. Ж.Отгонбаяр. Улаанбаатар: Монсудар.
- Нандинбилиг, Г ба Дулам, С. (2020). *Монгол аман зохиолын онол II: Хүүрэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол*. Улаанбаатар: МУИС Пресс
- Нямсүрэн, Ц. (2017). *Монгол, грек туульсын бүтцийг харьцуулан судалсан нь*. Улаанбаатар: Үсэг хоршоо.
- Сампилдэндэв, Х. (2002). Буриад аман зохиол, зан үйлийг сурвалжилсан ажиглалт тэмдэглэл. *Монгол аман зохиолын товчоон*. 54-74.
- Соёлмаа, С. (2019). *Домгийн бүтэц-тэмдэг зүйн үүднээс шинжлэхүй (Монгол аман зохиолын жишээн дээр)*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Хүрэлшаа. (2016). *Монгол домгийн соёл судлал*. хөр. С.Өлзийсайхан, А.Амарсанаа. Улаанбаатар: Admon print.
- Цэрэнханд, Г. (2018). *Шашны психологийн ба бусад төрлийн бэлгэдэлт мэдээг К.Г.Юнг философийн үүднээс шинжилсэн онцлог*. Улаанбаатар: Тод бичиг.
- Монгол бичгээр**
- Kürelša. (1988). Mongᠭol geser-ün tuᠭuji da᠒i qubilaqui – qubilyaqui motif-i sinjilekü ni. [Монгол Гэсэрийн тууж дахь хувилахуй-хувилгахуй мотивыг шинжлэх нь] *Öbür Mongᠭol-un niigem-ün sinjilekü u᠒ayan* (II). 47-69.
- Англи хэлээр**
- Elli Köngäs Maranda & Pierre Maranda. (1971). *Structural Models in Folklore and Transformational essays*. Paris: Mouton.
- Ruth Finnegan. (1992). *Oral Traditions and the Verbal Arts*. London: Routledge.
- Vladimir Propp. (2009). *Morphology of the Folktale*, trans. Laurence Scott. Austin: University of Texas Press.
- William Bascom. (1965). The Forms of Folklore: Prose Narratives. *Journal of American Folklore*. 78 (307), 3-20. <https://doi.org/10.1525/9780520352131-003>.

Товчилсон нэр

ГХҮТ – Гонгорын хэлсэн үлгэр, туульс
 ЗААЗ – Захчин ардын аман зохиол
 МАДҮ – Монгол ардын домог үлгэр
 МДЧ – Монгол домгийн чуулган
 ТААЗ – Торгууд ардын аман зохиол

Summary

Oral and written literature exert a reciprocal influence on one another. Characters and motifs from folktales and epics that circulate among communities often shape written literature, while conversely, folktales and legends initially preserved in written form may evolve into oral narratives within communities. A prominent example of this interrelation appears in myths and tales concerning *tengeriin dagina* and *tengeriin züüdunii khün*. One notable oral narrative a celestial woman (*tengeriin dagina* and *tengeriin züüdunii khün*) who descends from the sky to the human realm, marries a mortal man, and eventually returns to the celestial realm. This character, often referred to as the *tengeriin dagina* or the *tengeriin züüdunii khün*, represents a figure of transcendence and liminality between the human and divine worlds.

This study employs a structuralist approach to analyze a myth involving *tengeriin züüdunii khün*, seeking to illuminate the connections between character, motif, and conflict across myth, folktale, legend, and written literature. The use of *the tengeriin züüdunii khün* character in oral and written narratives, through motifs of resistance to marriage and family, reveals an archetypal character shaped by these recurring conflicts.

Key words: a celestial woman, *tengeriin züüdunii khün*, *tengeriin dagina*, marriage, conflict, mediator, archetype